



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татан буугдсан Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын харьяа Өмнеговь аймгийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 39,795,000.00 (гучин есөн сая долоон зуун ерэн таван мянга) төгрөгийн балансын үнэ, 15,293,195.48 (арван таван сая хоёр зуун ерэн гурван мянга нэг зуун ерэн таван төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3 Автомашиньг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001216
6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны ... дугаар сарын... өдрийн
 78 дугаар тогтооллын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР /ХУУЧИН НЭРЭЭР/-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЗАСГИЙН
 ГАЗРЫН АВТОБААЗАД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Автобус, Hyundai, E- County, ӨМЭ 41-01	2007/2020	39,795,000.00	15,293,195.48	24,501,804.52
	Нийт дүн		39,795,000.00	15,293,195.48	24,501,804.52
			(гучин есэн сая долоон зуун ерэн таван мянга)	(арван таван сая хоёр зуун ерэн гурван мянга нэг зуун ерэн таван төгрөг дөчин найман мөнгө)	(хорин дөрвөн сая таван зуун нэг мянга найман зуун дөрвөн төгрөг тавин хоёр мөнгө)